



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар A/438

Хэрлэн сум

Хан Хэнтий Чуулга бүтэц, орон тоог
шинэчилэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2023 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчилэн тогтоох тухай” 240, 241 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хан Хэнтий Чуулгын шинэ барилга ашиглалтад орж, MNS5634:2006 стандартын дагуу орон тоо нэмэгдэх шаардлагатай болсон тул бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажлын байрыг оновчтой тогтоон, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, гэрээ байгуулж, хэвийн үйл ажиллагаагаар хангаж ажиллахыг Хан Хэнтий Чуулгын дарга (Д.Цогт-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 08 дугаар сарын 07-ны
дугаар захирамжийн хавсралт

**Ардын Дуу Бүжгийн Хан Хэнтий Чуулгын
бүтэц орон тоо**

Анги	Нэгж	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
Захиргаа төлөвлөлтийн анги	Маркетинг, хүний нөөцийн анги	Ерөнхий менежер	1	ТҮСҮ-6
		Хүний нөөц	1	ТҮ-7
		Их эмч	1	ТҮ-7
		Маркетингийн менежер	3	ТҮ-7
		Архив, бичиг хэргийн эрхлэгч	1	ТҮ-5
		Онцгой гамшгаас хамгаалах ажилтан	1	ТҮ-5
	Санхүү аж ахуйн анги	Ерөнхий нягтлан бодогч	1	ТҮ-8
		аж ахуйн нярав	1	ТҮ-3
		Кассын нярав	1	ТҮСҮ-1
Уран бүтээлийн анги	Уран сайхны зөвлөл	Уран сайхны удирдагч	1	ТҮСҮ-6
		Ерөнхий найруулагч	1	ТҮСҮ-6
		Концертмейстер	1	ТҮСҮ-5
		Хормейстер	1	ТҮСҮ-5
		Бүжиг дэглээч	1	ТҮСҮ-5
		Хөгжмийн зохиолч	1	ТҮСҮ-5
		Драмын багш	1	ТҮСҮ-5
		Нот эрхлэгч	1	ТҮСҮ-3
		Туслах найруулагч	1	ТҮСҮ-5
		Хөгжмийн багш	1	ТҮСҮ-5
	Уран бүтээлчид	Бүжгийн багш	1	ТҮСҮ-5
		Дууны багш	1	ТҮСҮ-5
		Хөгжимчид	29	ТҮСҮ-5
		Бүжигчид	24	ТҮСҮ-5
		Дуучид	22	ТҮСҮ-5

Үйлчилгээ техникийн анги	Үйлдвэрлэл	Зохион байгуулагч	1	ТҮСҮ-3
		Хувцасны эрхлэгч	1	ТҮСҮ-3
		Зураач	1	ТҮСҮ-3
		Тайзны механист	2	ТҮСҮ-3
		оёдолчин	2	ТҮСҮ-1
	Техник	Цахилгаанчин	1	ТҮ-3
		Сан техникч	1	ТҮ-3
		Дууны техникч	1	ТҮСҮ-3
		Дууны оператор	1	ТҮСҮ-2
		Гэрлийн техникч	1	ТҮСҮ-3
		Гэрлийн оператор	1	ТҮСҮ-2
		Компьютерийн графикч	1	ТҮСҮ-4
		Жижүүр, цэвэрлэгч	3	ТҮ-1
		Жижүүр	5	ТҮ-1
		Үйлчлэгч	7	ТҮ-1
		Үтгагч	2	ТҮ-1
		Жолооч	2	ТҮ-3
		Мужаан	1	ТҮ-1
Нийт 132				